ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

## 2024 | IV



www.1212.mn

Улаанбаатар хот
2024 он

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

**2024**
4 сар

Улаанбаатар хот
2024


ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО
СТАТИСТИКИЙН
МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН
Хайх ...
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай
Data lab
тооллого судалгааны
микро мэдээллийн сан
Social network
/StatisticMGL
Лавлах утас
1900-1212
Цахим шуудан
information@nso.mn

**I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.**

- Сар: I, II, III, IV, V … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI … г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

**II. Дараах тэмдэглэгээг ашиглав.**

- … мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл

**III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ**

- мянга =1000
- сая $=10^{6}$
- тэрбум $=10^{9}$
- их наяд $=10^{12}$
- мян. мянга
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- $м^2$ метр квадрат
- $дм^2$ дециметр квадрат
- $км^2$ километр квадрат
- $м^3$ метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- Вт ватт
- кВт.ц киловатт цаг
- кал калори
- ккал килокалори
- Гкал гигакалори($=10^{9}$ калори)
- с секунд
- мин минут
- $мкг/м^3$ микрограмм метр куб
- м/с метр секунд
- ш ширхэг
- х.д.х хэвлэлийн даралтат хуудас
- 
- Үнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

**IV.** Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



**V**. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/




**VI.** Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.........................................................................................................4
Үндсэн үзүүлэлт..........................................................................................................7-9
I.Нийгмийн даатгал......................................................................................................7-10
II.Боловсрол..................................................................................................................10
III.Эрүүл мэнд..............................................................................................................11-14
IV.Гэмт хэрэг ...............................................................................................................15-18
V.Дүүргийн төсөв.........................................................................................................19-22
VI.Хэрэглээний үнэ.......................................................................................................23-27
VII.Дүүргийн аюулгүй байдал.......................................................................................28-29
VIII.Аж үйлдвэр.............................................................................................................30-34
IX.Нийтийн аж ахуй .....................................................................................................35-36
X.Төрийн бусад үйлчилгээ............................................................................................37-42

| БҮЛЭГ | | ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН: |
|---|---|---|
| | Үндсэн үзүүлэлтүүд /хүснэгт/ | Г.Пүрэвсүрэн |
| I | Нийгмийн даатгал, халамж | Г.Пүрэвсүрэн |
| II | Боловсрол | Ш.Наранмижид |
| III | Эрүүл мэнд | Ш.Наранмижид |
| IV | Гэмт хэрэг | Г.Пүрэвсүрэн |
| V | Дүүргийн төсөв | Г.Пүрэвсүрэн |
| VI | Хэрэглээний үнэ | Ш.Наранмижид |
| VII | Дүүргийн аюулгүй байдал | Г.Пүрэвсүрэн |
| VIII | Аж үйлдвэр | Ш.Наранмижид |
| IX | Нийтийн аж ахуй | Ч.Элбэгжаргал |
| X | Төрийн бусад үйлчилгээ | Г.Пүрэвсүрэн |

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 IV | 2024 IV | Өөрчлөлт хувь |
|---|---|---|---|---|
| Шинэ төрсөн хүүхэд | тоо | 591 | 636 | 7.6% |
| Халдварт өвчнөөр өвчлөгсөд | тоо | 42 | 343 | 7.2[1] |
| Дүүргийн төсвийн орлого | тэрбум.төг | 51.7 | 77.9 | 50.7% |
| Дүүргийн төсвийн зарлага | тэрбум.төг | 52.4 | 69.8 | 33.2% |
| Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт | пункт | 2.9 | 0.6 | -79.3% |
| Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст | 1US$ =₮ | 3 469.6 | 3 381.3 | -2.5% |

[1] Дахин өссөн

[1] Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2023 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| | Өрхийн тоо | Хүн амын тоо | Өрхийн дундаж ам бүлийн тоо[2] | Хүн ам зүйн ачаалал[3] |
|---|---|---|---|---|
| **Дүүргийн дүн** | **37 736** | **136 280** | **3.6** | **57.5** |
| 1 -р хороо | 864 | 3 604 | 4.2 | 67.2 |
| 2 -р хороо | 969 | 3 384 | 3.5 | 67.4 |
| 3 -р хороо | 1 602 | 5 812 | 3.6 | 62.9 |
| 4 -р хороо | 1 265 | 4 936 | 3.9 | 56.5 |
| 5 -р хороо | 1 221 | 4 735 | 3.9 | 56.6 |
| 6 -р хороо | 2 510 | 9 020 | 3.6 | 64.4 |
| 7 -р хороо | 1 758 | 6 018 | 3.4 | 54.1 |
| 8 -р хороо | 958 | 3 314 | 3.5 | 53.0 |
| 9 -р хороо | 1 554 | 5 580 | 3.6 | 53.8 |
| 10 -р хороо | 1 920 | 7 226 | 3.8 | 57.5 |
| 11 -р хороо | 1 226 | 4 417 | 3.6 | 51.6 |
| 12 -р хороо | 1 598 | 5 713 | 3.6 | 57.1 |
| 13 -р хороо | 1 768 | 6 497 | 3.7 | 58.0 |
| 14 -р хороо | 1 618 | 5 827 | 3.6 | 55.2 |
| 15 -р хороо | 2 125 | 7 683 | 3.6 | 59.1 |
| 16 -р хороо | 1 980 | 7 647 | 3.9 | 57.9 |
| 17 -р хороо | 2 214 | 7 822 | 3.5 | 54.9 |
| 18 -р хороо | 2 230 | 7 366 | 3.3 | 53.5 |
| 19 -р хороо | 1 972 | 6 954 | 3.5 | 55.9 |
| 20-р хороо | 1 320 | 4 772 | 3.6 | 54.7 |
| 21-р хороо | 1 782 | 6 878 | 3.9 | 56.7 |
| 22-р хороо | 1 122 | 4 077 | 3.6 | 56.1 |
| 23 -р хороо | 1 249 | 4 302 | 3.4 | 59.7 |
| 24 -р хороо | 911 | 2 670 | 2.9 | 63.5 |

[2] Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

[3] Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

# I. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 4 сард 267.9 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 107.2 (66.7%) сая төгрөгөөр өсөж, сангийн зарлага 78.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 81.8 (51.0%) сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 1.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сангуудаар, сая төгрөг




Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого 96.5 (75.2%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 0.2 (87.0%) сая төгрөгөөр тус тус өссөн бол, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 7.8 (60.6%) сая төгрөг, ҮОМШӨ–ний даатгалын сангийн орлого 529.8 (3.2%) сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарсан байна.

ЗУРАГ 1.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 1.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, сая төгрөг




Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 55.5 (43.3%) сая төгрөгөөр, ҮОМШӨ–ний даатгалын сангийн зарлага 1.6 (97.2%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 0.1 (25.5%) сая тус тус өссөн бол тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 9.2 (74.0%) сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамжийн сангаас 2024 оны 4 сард 102.7 мянган хүнд 33.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 304 (0.3%) мянган хүнээр, олгосон тэтгэвэр, тэтгэмж 4186.4 (14.4%) сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэттэй байна.

ЗУРАГ 1.4 ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, сая төгрөг




Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2024 оны 4 сарын байдлаар 2337 хүн хамрагдаж 3170.1 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 16 (0.7%)-аар өссөн бол олгосон мөнгөн тэтгэвэр 540.9 (20.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 68651 хүн хамрагдаж 24514.5 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 3.6 (5.6%) мянган хүнээр, олгосон тэтгэмж 1929.5 (8.5%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

## II.БОЛОВСРОЛЫН САЛБАР

Дүүргийн хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуульд суралцагчдийн тоо 29054 болж өмнөх оны мөн үеэс 2122 (7.9%) хүүхдээр нэмэгдсэн байна.2021-2022 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд нийт 12 890  хүүхэд хамрагджээ.

ХҮСНЭГТ 2.1 ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЕБС-Д СУРАЛЦАГЧДЫН ТОО, хүчин чадал

| Сургууль | 2022-2023 оны хичээлийн жил | | | 2023-2024 оны хичээлийн жил | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хүчин чадал | Хүүхдийн тоо | Бүлэг дүүргэлт | Хүчин чадал | Хүүхдийн тоо | Бүлэг дүүргэлт |
| **БҮГД** | **17 801** | **30477** | **36.6** | **17 801** | **31 688** | **750.3** |
| 5-р сургууль | 1 600 | 3 379 | 3 379 | 1 600 | 3 406 | 44.2 |
| 17-р сургууль | 1 240 | 2 316 | 2 316 | 1 240 | 2 301 | 37.5 |
| 23-р сургууль | 1 470 | 3 592 | 3 592 | 1 470 | 3 351 | 51.0 |
| 24-р сургууль | 1 270 | 3 747 | 3 747 | 1 270 | 3 707 | 43.6 |
| 37-р сургууль | 1 200 | 1 976 | 1 976 | 1 200 | 2 267 | 34.9 |
| 39-р сургууль | 1 040 | 1 839 | 1 839 | 1 040 | 2 076 | 38.4 |
| 49-р сургууль | 960 | 1 232 | 1 232 | 960 | 1 402 | 30.0 |
| 50-р сургууль | 1 370 | 2 634 | 2 634 | 1 370 | 2 674 | 44.6 |
| 57-р сургууль | 1 549 | 1 479 | 1 479 | 1 549 | 1 549 | 34.4 |
| 61-р сургууль | 812 | 915 | 915 | 812 | 996 | 30.2 |
| 72-р сургууль | 1 400 | 2 230 | 2 230 | 1 400 | 2 378 | 35.0 |
| 112-р сургууль | 120 | 82 | 82 | 120 | 35 | 5.0 |
| 117-р сургууль | 640 | 1 462 | 1 462 | 640 | 1 742 | 34.8 |
| 138-р сургууль | 180 | 315 | 315 | 180 | 450 | 30.0 |
| 139-р сургууль | 180 | 439 | 545 | 180 | 381 | 31.8 |
| 140-р сургууль | 180 | | 434 | 180 | 420 | 33.0 |
| 149-р сургууль | 720 | 434 | 758 | 720 | 876 | 29.2 |
| 145-р сургууль | 180 | - | 35.0 | 180 | 236 | 35.0 |
| Бадмаараг | 350 | 270 | 34.2 | 350 | 342 | 34.2 |
| Эрдэм цогцлохуй | 120 | - | 24.0 | 120 | 120 | 24.0 |
| Ивээх эрдэм | 150 | - | 20.0 | 150 | 60 | 20.0 |
| Олонлог гэгээ | 720 | 356 | 26.6 | 720 | 638 | 26.6 |
| Бэтүб | 100 | 38 | 4.1 | 100 | 33 | 4.1 |
| Олонлог төв сургууль | - | 522 | - | - | - | - |
| Оюут | - | 102 | - | - | - | - |
| Ертөнц 1 | - | 109 | - | - | - | - |
| Атланта | - | 14 | - | - | - | - |
| Тоолон | - | 12 | - | - | - | - |
| Тусгал | 250 | 152 | 19.1 | 250 | 248 | 19.1 |

*Эх үүсвэр: Боловсролын хэлтэс

ХҮСНЭГТ 2.2 ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ТОО, хүчин чадал

| Үзүүлэлт | 2019-2020 | 2020-2021 | 2021-2022 | 2022-2023 | 2023-2024 |
|---|---|---|---|---|---|
| 2-5 настай хүүхэд | 14 585 | 7 336 | 12 890 | 9 971 | 9 285 |
| СӨБ-д хамрагдсан | 10 584 | 7 336 | 12 890 | 9 971 | 9 285 |
| Хүчин чадал | 7 580 | 4 001 | 8 445 | 8 445 | 8 103 |
| Хүчин чадал хэтрэлт | 39.6 | 83.3 | 71.5 | 71.5 | 71.5 |
| Цэцэрлэгийн тоо | 53 | 50 | 54 | 53 | 52 |
| Үүнээс: Улсын цэцэрлэг | 31 | 32 | 39 | 38 | 40 |
| Хувийн цэцэрлэг | 22 | 18 | 15 | 15 | 12 |

*Эх үүсвэр: Боловсролын хэлтэс

# ЭРҮҮЛ МЭНД, 2024 оны эхний 4 сарын байдлаар

ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид

| | | |
|---|---|---|
| 2023 IV | 3 608 | |
| 2024 IV | 2 492 | 30.9% ↓ |

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид, 10 000 хүн амд

| | | |
|---|---|---|
| 2023 IV | 27.2 | |
| 2024 IV | 24.5 | 9.9% ↓ |

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)

| | |
|---|---|
| 2023 IV | 11.2 |
| 2024 IV | 6.6 |

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)

| | |
|---|---|
| 2023 IV | 2.5 |
| 2024 IV | 3.1 |

# IV. ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2024 оны эхний 4 сард 629 эх амаржиж, 636 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 168 (20.6%)-аар, мэндэлсэн хүүхэд 165 (25.9%)-аар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 3.1 ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2024 оны эхний 4 сарын байдлаар

| Үзүүлэлт | 2022 I-IV | 2023 I-IV | 2024 I-IV | Өсөлт, бууралт 2022-2023 | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| Амаржсан эхийн тоо | 811 | 797 | 629 | -168 | -21.1% |
| Амьд төрсөн хүүхэд | 819 | 801 | 636 | -165 | -20.6% |
| Нас барсан хүн | 252 | 269 | 254 | -15 | -5.6% |
| Эхийн эндэгдэл | - | - | - | - | - |
| 0-1 насны нялхасын эндэгдэл | 11 | 9 | 4 | -5 | -55.6 |
| 1-5 настай хүүхдийн эндэгдэл | 1 | 2 | 2 | - | - |
| Амьгүй төрөлт | 4 | 4 | 5 | 1 | 25.0% |
| Гэрийн төрөлт | 4 | 2 | 3 | 1 | 50.0% |
| Хяналтгүй төрөлт | 1 | 5 | 6 | 1 | 20.0% |

[1]-дахин

*Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

2024 оны эхний 4 сард 280427 хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25973 (10.2%)-аар өссөн байна. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 2492 болж 1116 (30.9%) хүнээр буурчээ.

ЗУРАГ 3.1 ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



ХҮСНЭГТ 3.2 ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний 4 сарын байдлаар

| Төрөл | 2022 IV | | 2023 IV | | 2024 IV | | Өөрчлөлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бодит тоо | 10 000 хүнд ногдох | Бодит тоо | 10 000 хүнд ногдох | Бодит тоо | 10 000 хүнд ногдох | |
| **Дүүргийн дүн** | **10 225** | **676.31** | **401** | **27.21** | **343** | **24.50** | **-9.9%** |
| Гепатит | 5 | 0.33 | 6 | 0.41 | 3 | 0.21 | -50.0% |
| Цусан суулга | 25 | 1.65 | 24 | 1.63 | 8 | 0.57 | -66.7% |
| Сальмоненнез | 3 | 0.20 | 4 | 0.27 | 6 | 0.43 | 50.0% |
| Хоолны хордлого | 1 | 0.07 | - | 0.00 | - | 0.00 | - |
| Менингит | | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | - |
| Салхин цэцэг | 26 | 1.72 | 128 | 8.68 | 136 | 9.70 | 6.3% |
| Гахайн хавдар | - | 0.00 | 0 | 0.00 | 8 | 0.57 | - |
| Улаан эсэргэнэ | 1 | 0.07 | 6 | 0.41 | 12 | 0.86 | 100.0% |
| Ёлом | 1 | 0.07 | 2 | 0.14 | 5 | 0.36 | 1.5[1] |
| Бруцеллёз | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | - |
| Гар, хөл, ам | 1 | 0.07 | 63 | 4.27 | 31 | 2.21 | -50.8% |
| Эритема | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | - |
| Хачигт энцефалит | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | - |
| Хачигт риккетсиоз | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | - |
| Хумхаа | - | - | 1 | 0.00 | - | - | -100.0% |
| Ковид-19 | 9 949 | 658.06 | - | 0.00 | - | 0.00 | - |
| Тэмбүү | 72 | 4.76 | 54 | 3.66 | 50 | 3.56 | -7.4% |
| Төрөлхийн тэмбүү | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | - |
| Заг хүйтэн | 23 | 1.52 | 17 | 1.15 | 9 | 0.64 | -47.1% |
| Сүрьеэ | 66 | 4.37 | 60 | 4.07 | 38 | 2.71 | -36.7% |
| Мөөгөнцөр | 17 | 1.12 | 8 | 0.54 | 4 | 0.29 | -50.0% |
| Трихомониаз | 35 | 2.32 | 28 | 1.90 | 33 | 2.35 | 17.9% |
| ХДХВ/ДОХ | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | - |

[1]-Дахин их

*Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

Бэлгийн замын халдварт өвчин 96 байгаа нь нийт халдварт өвчний 28.0 хувийг эзэлж байна. Ковид-19 халдварт өвчлөл гараагүй байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

# ГЭМТ ХЭРЭГ, 2023 оны эхний 4 сарын байдлаар

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

| 2023 IV | 2024 IV | |
|---|---|---|
| 1139 | 1038 | 8.9%↓ |

Дүүргээр




Гэмт хэргийн улмаас

| Хохирсон хүн | Гэмтсэн хүн | Нас барсан хүн |
|---|---|---|
| 981 | 176 | 12 |

# IV. ГЭМТ ХЭРЭГ

2024 оны 4 дүгээр сард дүүргийн хэмжээнд нийт 1038 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 101 (8.9%) хэргээр буурсан байна. Нийт гэмт хэргийн 214 (20.6%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 22 (2.1%) нь хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг хэрэг, 22 (2.1%) нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг хэрэг, 211 (20.3%) нь хулгайн хэрэг, 15 (1.4%) нь дээрэмдэх хэрэг, 367 (35.4%) нь залилан мэхлэх гэмт хэрэг, 33 (3.2%) нь алдаатай гүйлгээ, гээгдсэн хөрөнгө завших хэрэг, 30 (2.9%) нь автотээврийн ХАБ, АЖ зөрчих гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, цагдаагийн хэлтсээр, төрлөөр

| Дүүргийн дүн | 2024 IV | Үүнээс: Цагдаагийн I хэлтэс | II хэлтэс |
|---|---|---|---|
| | **1038** | **621** | **417** |
| Хүний амьд явах эрхийн эсрэг | 15 | 8 | 7 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 214 | 105 | 109 |
| Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг | 22 | 19 | 3 |
| Өмчлөх эрхийн эсрэг | 663 | 418 | 245 |
| Эдийн засгийн | 23 | 11 | 12 |
| Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг | - | - | - |
| Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг | 3 | - | 3 |
| Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг | 9 | 5 | 4 |
| Хүрээлэн байгаа орчны эсрэг | 2 | 1 | 1 |
| Соёлын өвийн эсрэг | 4 | - | 4 |
| Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг | 8 | 7 | 1 |
| Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | 30 | 17 | 13 |
| Бусад | 45 | 30 | 15 |

*Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс

ЗУРАГ 4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



## ХҮСНЭГТ 4.2 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, хороогоор, төрлөөр

| Чингэлтэй дүүргийн хороод | Хүний амьд явах эрхийн эсрэг 10.1-10.6 | Хүнийг алах 10.2 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 11.7 | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг | Үүнээс: хүчиндэх | Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 13.1-13.13 | Өмчлөх эрхийн эсрэг /17.1-17.12/ | Хулгайлах /17.21/ | Дээрэмдэх | Үүнээс: Залилан мэхлэх /17.3/ | Үүнээс: Соёлын өвийн эсрэг | Үүнээс: Хөрөнгө завших 17.5 | Үүнээс: Нийтийн албаны ашиг | Эдийн засгийн /18.1-18.18/ | Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг 26.4 | Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг 821.1-21-14/ | Алдаатай гүйгээ андуурагдсан илгээмж, гээгдэх эд хөрөнгө, алдуул мал завших 17.6 | Хүчиндэх 12.1.4 | Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бусаар ашиглах | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журамын эсрэг 27.1 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүүргийн дүн | 15 | 8 | 214 | 184 | 22 | 16 | 22 | 663 | 211 | 15 | 367 | 4 | 10 | 9 | 23 | 8 | 3 | 33 | 8 | 17 | 30 |
| 1 хороо | | | 3 | 3 | | | 4 | 63 | 24 | | 30 | 3 | 2 | 2 | 4 | | | 5 | | 4 | 2 |
| 2 хороо | 1 | 1 | 9 | 9 | | | | 51 | 19 | 2 | 26 | | 2 | 1 | 2 | 1 | | 2 | | | 1 |
| 3 хороо | 1 | | 7 | 5 | 1 | 1 | 4 | 87 | 20 | | 53 | 1 | 2 | | 2 | 1 | | 6 | | 2 | 1 |
| 4 хороо | | | 7 | 7 | | | 7 | 37 | 15 | 1 | 17 | | | 1 | | 3 | 1 | 1 | | 2 | 4 |
| 5 хороо | 1 | | 23 | 19 | 3 | 3 | 3 | 100 | 21 | 1 | 65 | | 3 | 1 | 2 | | 2 | 6 | | 3 | 1 |
| 6 хороо | 1 | | 18 | 16 | 3 | 3 | 1 | 38 | 14 | 2 | 18 | | | | 1 | 1 | | 3 | 2 | 3 | 4 |
| 7 хороо | 3 | 2 | 15 | 13 | 1 | | | 23 | 9 | 1 | 8 | | | | | | | 3 | | | 1 |
| 8 хороо | 1 | 1 | 10 | 10 | 1 | 1 | | 9 | 5 | 1 | 3 | | | | | | | | | | 1 |
| 9 хороо | | | 10 | 8 | 3 | 2 | | 8 | 3 | | 2 | | 1 | | | | | | 2 | 1 | 2 |
| 10 хороо | 2 | 1 | 5 | 5 | | | 2 | 20 | 7 | | 10 | | | | 1 | 1 | | 1 | | | 1 |
| 11 хороо | 1 | | 10 | 8 | 1 | 1 | | 20 | 5 | 2 | 13 | | | | 3 | | | | | | 1 |
| 12 хороо | 1 | 1 | 16 | 11 | 2 | | | 26 | 6 | 1 | 18 | | | 1 | 1 | | | | | | 1 |
| 13 хороо | | | 25 | 22 | 2 | 2 | | 20 | 8 | 1 | 9 | | | 1 | | | | 2 | | | 2 |
| 14 хороо | 2 | 1 | 6 | 6 | 1 | | | 23 | 9 | | 12 | | | 1 | 1 | | | 1 | | | 2 |
| 15 хороо | | | 5 | 4 | 1 | 1 | | 25 | 6 | 2 | 16 | | | | 1 | | | | 2 | | |
| 16 хороо | | | 5 | 5 | | | | 14 | 3 | 1 | 8 | | | | | | | 1 | | | 1 |
| 17 хороо | 1 | 1 | 6 | 6 | | | | 6 | 2 | | 4 | | | | 1 | | | | | | |
| 18 хороо | | | 9 | 7 | 1 | 1 | 1 | 16 | 5 | | 11 | | | | | | | | | | 1 |
| 19 хороо | | | 7 | 6 | 1 | | | 19 | 9 | | 9 | | | | 1 | | | | | | 2 |
| 20 хороо | | | 3 | 2 | | | | 2 | | | 2 | | | | 1 | 1 | | | | | |
| 21 хороо | | | 5 | 4 | 1 | | | 15 | 9 | | 6 | | | 1 | | | | | | | |
| 22 хороо | | | 2 | 1 | | 1 | | 8 | 2 | | 6 | | | | | | | | 2 | | |
| 23 хороо | | | 2 | 2 | | | | 9 | 1 | | 7 | | | | | | | 1 | | | 2 |
| 24 хороо | | | 6 | 5 | | | | 24 | 9 | | 14 | | | | 2 | | | 1 | | | |

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2024 оны 4 дүгээр сард, тэрбум төгрөг




Чингэлтэй дүүргийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын бүтэц



# V. ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нэгдсэн тэнцэл 2024 оны 4 дүгээр сард 8.1 тэрбум төгрөг гарсан байна.

ЗУРАГ 5.1 ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 4 сард




Дүүргийн төсвийн нийт орлого 2024 оны 4 дүгээр сард 77.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 3.2 тэрбум төгрөгөөр (4.2%) илүү бүрджээ. Төсвийн нийт орлогын 96.0 хувийг татварын орлого, 3.6 хувийг татварын бус орлого, 0.4 хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна.

2024 оны 4 сард дүүргийн татварын орлого 74.8 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 1.3 тэрбум төгрөгөөр буюу 1.7 хувиар илүү, татварын бус орлого 2.8 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 2.1 тэрбум төгрөгөөр 2.8 хувиар дахин илүү бүрдсэн байна.

ЗУРАГ 5.2 ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөгөөр



ХҮСНЭГТ 5.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөгөөр, 2024 оны 4 сард

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Нийт орлого ба тусламжийн дүн** | **74 742.3** | **77 909.3** | **3 167.0** | **-4.2%** |
| А. Урсгал орлого | 74 235.2 | 77 571.2 | 3 336.0 | -4.5% |
| 1. Татварын орлого | 73 514.5 | 74 798.7 | 1 284.2 | -1.7% |
| 1.1. Орлогын албан татвар | 64 864.5 | 66 756.2 | 1 891.7 | 2.9% |
| 1.2. Өмчийн татвар | 2 103.4 | 1 866.0 | -237.4 | -11.3% |
| 1.3. Бусад татвар (төлбөр хураамж) | 6 546.5 | 6 176.5 | -370.0 | 5.7% |
| 2. Татварын бус орлого | 720.7 | 2 772.5 | 2 051.8 | 2.8¹ |
| Б. Хөрөнгийн орлого | - | - | - | - |
| В. Тусламжийн орлого | 507.1 | 338.1 | -169.0 | -33.3% |

*Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2024 оны 4 дүгээр сард 69.8 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 13.2 тэрбум төгрөг (15.9%) буурсан байна. Төсвийн нийт зарлагын 5.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.6 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 26.6 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал, 69.3 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөгөөр, 2024 оны 4 сард

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **83 043.8** | **69 799.6** | **-13 244.2** | **-15.9%** |
| А. Урсгал зарлага | 72 651.4 | 66 894.2 | -5 757.2 | -7.9% |
| 1. Бараа, үйлчилгээний зардал | 23 147.8 | 18 543.2 | -4 604.6 | -19.9% |
| 1.1. Цалин, хөлс | 4 474.1 | 3 614.3 | -859.8 | -19.2% |
| 1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж | 575.9 | 434.1 | -141.8 | -24.6% |
| 1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал | 18 097.8 | 14 494.8 | -3 603.0 | -19.9% |
| 2. Зээлийн үйлчилгээний төлбөр | - | - | - | - |
| 3. Татаас ба урсгал шилжүүлэг | 49 503.6 | 48 351.1 | -1 152.5 | -2.3% |
| 3.1. Татаас | - | - | - | - |
| 3.2. Урсгал шилжүүлэг | 49 503.6 | 48 351.1 | -1 152.5 | -2.3% |
| Б. Хөрөнгийн зардал | 10 392.4 | 2 905.3 | -7 487.1 | -72.0% |
| Хөрөнгө оруулалт | 10 392.4 | 2 905.3 | -7 487.1 | -72.0% |

*Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

ЗУРАГ 5.3 ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2024 оны эхний 4 сарын байдлаар





# VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өслөө. 2024 оны 04 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 2.6 хувь өссөн ба өмнөх сартай харьцуулахад 0.6 хувиар өссөн байна.

ЗУРАГ 6.1 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар




Хэрэглээний үнийн индекс 2024 оны 04 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 2.6 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 7.0 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 1.0 хувь, хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнэ 1.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 1.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 3.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.3 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.5 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.7 хувь, Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 0.7 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.3 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 0.3 хувиар тус тус өөрчлөлт орсон байна.

ХҮСНЭГТ 6.1. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр | 2023-IV / 2022-IV | 2024-IV / 2023-IV | 2024-IV / 2023-XII | 2024-IV / 2024-III |
|---|---|---|---|---|
| Ерөнхий индекс | 112.1 | 106.1 | 102.6 | 100.6 |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 115.6 | 107.5 | 107.0 | 101.8 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 109.4 | 104.3 | 101.0 | 100.2 |
| Хувцас, бөс бараа, гутал | 115.7 | 104.5 | 101.2 | 99.8 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 119.6 | 105.7 | 101.7 | 100.5 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 113.6 | 105.4 | 103.1 | 100.5 |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | 107.0 | 108.1 | 102.3 | 100.0 |
| Тээвэр | 104.0 | 99.7 | 99.5 | 100.0 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 101.9 | 102.2 | 102.4 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 110.2 | 103.9 | 101.7 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ | 110.7 | 121.2 | 100.0 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 119.1 | 105.1 | 100.7 | 100.0 |
| Даатгал, Санхүүгийн үйлчилгээ | 108.4 | 102.3 | 102.3 | 100.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 122.0 | 114.1 | 100.3 | 100.1 |

Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон захууд болох Алтжин, Бөмбөгөр, Нарантуул-2, Хүчит шонхор захуудаас авсан барааны бүтээгдэхүүний дундаж үнэ.

ЗУРАГ 6.2 АЛТАН ТАРИА ДЭЭД ГУРИЛ, АТАР ТАЛХНЫ ҮНЭ, жил бүрийн 4 сард, төгрөгөөр




ХҮСНЭГТ 6.2. БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, төгрөгөөр, жил бүрийн 4 сард

| Бүтээгдэхүүний нэр | Хэмжих нэгж | 2022 IV | 2023 IV | 2024 IV |
|---|---|---|---|---|
| Алтан тариа 1-р зэрэг | кг | 1 400 | 2 125 | 2 398 |
| Атар талх | ш | 1 600 | 2 249 | 2 500 |
| Цагаан будаа | кг | 4 600 | 4 849 | 4 300 |
| Шар будаа | кг | 3 575 | 4 500 | 3 150 |
| Хонины мах /ястай/ | кг | 12 000 | 13 982 | 14 369 |
| Үхрийн мах /ястай/ | кг | 13 000 | 16 496 | 16 492 |
| Адууны мах | Кг | 11 000 | 14 500 | 15 955 |
| Тахианы гуя | кг | - | 12 748 | 14 481 |
| Сүү задгай | л | 2 500 | - | - |
| Хорхой ааруул | кг | 24 000 | 26 476 | 28 374 |
| Өндөг | ш | 455 | 495 | 650 |
| Ургамлын тос | л | 6 500 | 11 216 | 9 000 |
| Алим, кг | кг | 6 250 | 9 330 | 6 299 |
| Банана, шар | кг | 5 875 | 8 411 | 7 000 |
| Төмс | кг | 1 500 | 1 598 | 1 800 |
| Лууван | кг | 3 250 | 2 236 | 3 000 |
| Сонгино | кг | 2 750 | 3 307 | 3 500 |
| Элсэн чихэр | кг | 3 600 | 3 550 | 4 000 |
| Эдийн саван "Popular" | ш | 1 275 | - | - |
| Угаалгын нунтаг "OMO" | ш | 2 550 | 5 949 | 7 500 |
| Аяга, таваг угаагч шингэн, "Fairy" | ш | 4 150 | 4 373 | 5 800 |

ЗУРАГ 6.3 НЭГ КГ ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 сард, төгрөгөөр




ЗУРАГ 6.4 НЭГ КГ ЛУУВАН, ТӨМСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 сард, төгрөгөөр




ЗУРАГ 6.5 ШАТАХУУНЫ ҮНЭ, жил бүрийн 4 сард, төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:
Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^{L} = \sum\left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right)\cdots\left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

$I_{ct}^{L}$ – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)
$t$ – тайлант үе
$i$ – бараа, үйлчилгээ
$o$ – суурь үе
$P_t^i$ - i барааны тайлант үеийн үнэ
$P_0^i$ – i барааны суурь үеийн үнэ
$Q_0^i$- i барааны суурь үеийн жин

# ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ, 2024 оны эхний 4 сарын байдлаар

| Торгуулсан жолоочийн тоо | | | Торгуулсан нийт хэмжээ /сая,төгрөг/ | | |
|---|---|---|---|---|---|
| 2023 IV | 2024 IV | | 2023 IV | 2024 IV | |
| 42 992 | 31 459 | 26.8% ↓ | 1 160.0 | 506.5 | 56.3% ↓ |

## НИЙТ ЗӨРЧИЛ 31 459

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй. боловчтээврийн хэрэгсэл жолоодсон
293

Эгнээ байраа буруу эзэлсэн
1 002

Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон
2 352

Хориглосон нөхцөлөөр зогссон
6 863

Бусад
18 897



Хамгаалах бүс хэрэглээгүй
1 723

Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн
20

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэнүедээ тээврийн хэрэгсэл жолоодсон
309

# VII. ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Зам тээврийн осол, зөрчил: Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид 2024 оны 4 дүгээр сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 7936 зөрчил илрүүлж, 68 хүнд торгож, эрх хасах, 21 хүнд шүүхээр баривчлах шийтгэл оногдуулсан байна.

ХҮСНЭГТ 7.1 ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

| Торгууль | 2022 I-IV | 2023 I-IV | 2024 I-IV |
|---|---|---|---|
| Торгуулсан хүний тоо | 24 516 | 42 992 | 31 462 |
| Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/ | 888.8 | 1 160.0 | 506.5 |

ХҮСНЭГТ 7.2 ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

| Зөрчлийн хэлбэр | 2022 I-IV | 2023 I-IV | 2024 I-IV |
|---|---|---|---|
| **НИЙТ ЗӨРЧИЛ** | **14 275** | **43 990** | **31 459** |
| Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон | 762 | 960 | 309 |
| Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон | 138 | 371 | 293 |
| Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон | 487 | 2 837 | 2 352 |
| Хамгаалах бүс хэрэглээгүй | 208 | 1 627 | 1 723 |
| Хориглосон нөхцөлөөр зогссон | 2 301 | 13 392 | 6 863 |
| Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн | 2 | 7 | 20 |
| Эгнээ байраа буруу эзэлсэн | 169 | 921 | 1 002 |
| Бусад зөрчил | 4 485 | 23 872 | 18 897 |

# АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2024 оны эхний 4 сарын байдлаар

## Уул уурхайн олборлолт аж үйлдвэр /сая төгрөг/




## Боловсруулах аж үйлдвэр /сая төгрөг/




## Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа /сая төгрөг/



# VIII. АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 16.0 хувиар өссөн. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 25071.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8333.1 (24.9%) сая төгрөгөөр бууржээ. Үүнд: боловсруулах үйлдвэрлэлийн салбар 18729.5 (25.5%) сая төгрөгөөр, уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар 3920.6 (24.1%) сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 2421.1 (2.7%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 8.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 18729.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6410.0 (25.5%) сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл 375.5 (91.4%) сая төгрөг, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл 632.7 (43.1%), хүнс ундааны үйлдвэрлэл 6567.4 (35.3%) сая төгрөг, бусад боловсруулах үйлдвэрлэл 5529.9 (15.1%) сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын 2024 оны 4 дугаар сарын борлуулалт 28030.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5827.1 (17.2%) сая төгрөгөөр буурахад уул уурхайн олборлох аж үйлдвэр 4097.6 (26.4%) буурсан нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 8.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

| Салбар | | Нийт бүтээгдэхүүн | | | Өсөлт/Бууралт | | Бүтэц /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022 IV | 2023 IV | 2024 IV | Дүнгээр | Хувиар | |
| | | Мян.төг | | | | | |
| **Нийт дүн** | | **18 492 393.9** | **33 404 216.4** | **25 071 124.7** | **-8 333 091.7** | **-24.9%** | **100.0%** |
| 1 | **Уул уурхайн олборлох аж үйлдвэр** | **5 039 581.4** | **5 166 568.9** | **3 920 572.5** | **-1 245 996.4** | **-24.1%** | 15.6% |
| | Нүүрс | - | 450 335.8 | 401 200.0 | -49 135.8 | - 10.9% | |
| | Өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт | 2,043,966.6 | 638 399.4 | 1 172 327.2 | 533 927.8 | 83.6% | |
| | Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт | - | | 142 240. | 142 240. | - | |
| | Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 2 995 614.8 | 4 077 833.7 | 2 204 805.3 | -1 873 028.4 | -45.9% | |
| 2 | **Боловсруулах аж үйлдвэр** | **10 618 611.5** | **25 139 431.5** | **18 729 502.2** | **-6 409 929.3** | **-25.5%** | 74.7% |
| | Хүнс ундааны үйлдвэрлэл | 2 694 142.4 | 10 155 786.2 | 6 567 434.6 | -3 588 351.6 | -35.3% | |
| | Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл | 1 941 089.2 | 4 381 403. | 375 483.9 | -4 005 919.1 | -91.4% | |
| | Хувцас үйлдвэрлэл | 1 936 215.1 | 1 767 710.9 | 2 667 593.3 | 899 882.4 | 50.9% | |
| | Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | - | 1 112 615. | 632 724. | - 479 891. | -43.1% | |
| | Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа | 560 238.9 | 999 856.3 | 1 341 626.4 | 341 770.1 | 34.2% | |
| | Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл | - | 55 498.6 | 65 394.1 | 9 895.5 | 17.8% | |
| | Тавилга үйлдвэрлэл | 395 547. | 154 169.9 | 1 549 349.4 | 1 395 179.5 | 905.0% | |
| | Бусад боловсруулах үйлдвэрлэл | 3 091 378.9 | 6 512 391.6 | 5 529 896.5 | - 982 495.1 | -15.1% | |
| 3 | **Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа** | **2 834 201.** | **3 098 216.** | **2 421 050.** | **- 677 166.** | **-21.9%** | 9.7% |
| | Хог хаягдал цуглуулах, зайлуулах | 2 834 201. | 3 098 216. | 2 421 050. | - 677 166. | -21.9% | |
| **Борлуулалтын орлого** | | **19 327 452.3** | **33 858 066.6** | **28 030 953.2** | **-5 827 113.4** | **-17.2%** | 11.8% |

Энэ оны 4-р сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн уул уурхайн олборлох үйлдвэрлэл 3920.6 (15.6%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1246.0 (24.1%) сая төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэл 18729.5 (74.7%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3588.4 (25.5%) сая төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2421.03 (12.7%) сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 67.9 (2.7%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 8.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

| Салбар | 2022 IV | 2023 IV | 2024* IV | 2024* Гадаад | 2024* IV / 2023 IV |
|---|---|---|---|---|---|
| | Сая.төг | | | | хувь |
| **Нийт дүн** | **19 327.5** | **33 858.1** | **28 030.9** | **6 362.6** | **-17.2%** |
| Уул уурхай, олборлох аж үйлдвэр | 5 039.6 | 5 569.3 | 4 097.6 | 183.1 | **-26.4%** |
| Боловсруулах аж үйлдвэр | 11 453.7 | 25 190.6 | 20 813.6 | 6 179.5 | **-17.4%** |
| Ус хангамж, сувагжилтын систем | 2 834.2 | 3 098.2 | 3 119.7 | . | **0.7%** |

2024 оны 4-р сарын байдлаар уул уурхайн олборлох аж үйлдвэр 1694.4 сая, боловсруулах үйлдвэрлэл 4369.5 сая, ус хангамж, сувагжилтын систем 698.6 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан байна.

ЗУРАГ 8.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, салбараар, сараар, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс: Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томьёог ашиглан тооцно.

Тооцох аргачлал:
Ласпейрсийн биет хэмжээний индексийн томьёо:

$$I_{LQ} = \frac{\sum(Q_t \cdot P_0)}{\sum(Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum(\frac{Q_t}{Q_0}) \cdot W_0 \cdot 100$$

Qt- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ
$Q_0$- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ
$P_0$- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ
$W_0$- Жин

## НИЙТИЙН АЖ АХУЙ, 2024 оны 4 сарын байдлаар

ЦЭВЭРЛЭСЭН ЗАМ ТАЛБАЙ - 1 800 м²

ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ



2023 IV 6 282.4 мян.м³

2024 IV 6 301.9 мян.м³

Гэр хороолол — 5 671.7 — 90.0%

Албан газар — 630.2 — 10.0%

АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО - 294.9 сая.төг

Гэр хороолол — 265.4 — 90.0%

Албан газар — 29.5 — 10.0%

Дүүргийн хэмжээнд 2024 оны 4 сард 1800м2 талбай цэвэрлэж, 6301.9 мян.м3 хог тээвэрлэсэн байна. Ажил үйлчилгээний орлого 294.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.9 сая төгрөгөөр (0.3%) өссөн үзүүлэлтэй байна.



# IX. НИЙТИЙН АЖ АХУЙ

Чингэлтэй дүүргийн хувьд нийт цэвэрлэгээний ажил, хог хаягдлыг Тохижилт үйлчилгээний байгууллага болон Найши ХХК нь хариуцаж ажилладаг.

Дүүргийн хэмжээнд 2024 оны 4 сард 1800 мян.м$^2$ зам талбай цэвэрлэж, 6301.9 мян.м$^3$ хог тээвэрлэсэн байна. Тээвэрлэсэн хог өмнөх жилийн мөн үеэс 19.5 мян.м$^3$ (0.3%) өссөн байна.

Ажил үйлчилгээний орлого 294.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.9 сая төгрөгөөр (0.3%) өссөн байна. Орлогын эх үүсвэрийг ангилбал 90.0% гэр хорооллоос, 10.0%-ийг албан газраас олсон орлого эзэлж байна.

ХҮСНЭГТ 9.1. ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2024 оны 4 сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2022 IV | 2023 IV | 2024 IV | Өсөлт бууралт (хувь) |
|---|---|---|---|---|---|
| Цэвэрлэсэн талбай | мян.м$^2$ | 1800.0 | 1800.0 | 1800.0 | - |
| Тээвэрлэсэн хог | мян.м$^3$ | 5454.0 | 6282.4 | 6301.9 | 0.3% |
| Орон сууц | Тн | - | - | - | - |
| Гэр хороолол | тн | 4908.6 | 5654.2 | 5671.7 | 0.3% |
| Албан газар | тн | 545.4 | 628.2 | 630.2 | 0.3% |
| Зам талбай | Тн | - | - | - | - |
| Ажил үйлчилгээний орлого | сая.төг | 255.2 | 294.0 | 294.9 | 0.3% |
| Зам талбай | сая.төг | - | - | - | - |
| Гэр хороолол | сая.төг | 229.7 | 264.6 | 265.4 | 0.3% |
| Орон сууц | сая.төг | - | - | - | - |
| Албан газар | сая.төг | 25.5 | 29.4 | 29.5 | 0.3% |

* Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээний байгууллага, Найши ХХК

# X. ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэний бүртгэлийн үйлчилгээ: 2024 оны эхний 4 сард Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээ 25978 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 7066 (37.4%) хүнээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэрлэлт, хүүхэд үрчлэлт, овог нэр өөрчлөх бүртгэл, иргэний үнэмлэх олгох бүртгэлүүд тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 10.1 ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, үйлчилгээний төрлөөр

| Үзүүлэлт | 2023 IV | 2024 IV | 2024 IV / 2023 IV |
|---|---|---|---|
| | Дунгээр | | Хувь |
| **Нийт** | **18 912** | **25 978** | **37.4** |
| Шинэ төрсөн | 838 | 957 | 14.2 |
| Гэрлэлт | 237 | 228 | -3.8 |
| Гэр бүл цуцлалт | 111 | 129 | 16.2 |
| Хүүхэд үрчлэлт | 20 | 10 | -50.0 |
| Эцэг тогтоосон | 18 | 32 | 2.4[1] |
| Овог, нэр өөрчлөх | 74 | 42 | -43.2 |
| Шилжин ирсэн | 514 | 2 822 | 3.5[1] |
| Лавлагаа | 9 626 | 16 630 | 72.8 |
| Иргэний үнэмлэх олголт: | 7 474 | 5 128 | -41.0 |
| 16 нас хүрч шинээр авсан | 653 | 1 168 | 78.9 |
| Дахин олголт | 6 821 | 3 960 | 58.1 |

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

## ОНЦГОЙ БАЙДАЛ, 2024 оны эхний 4 сарын байдлаар

Онцгой байдлын хэлтэс нь 2024 оны эхний 4 сарын байдлаар нийт 131 гал түймэр, гамшиг ослын дуудлагаар ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 62 тохиолдлоор (32.1%) буурсан байна.



Онцгой байдал: Онцгой байдлын хэлтэс нь 2024 оны эхний 4 сард үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт 131 гал түймэр гамшиг ослын дуудлагаар ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 62 тохиолдлоор (32.1%) буурсан байна.

ХҮСНЭГТ 10.2. ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГА ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2024 оны эхний 4 сарын байдлаар

| Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2023 IV | 2024 IV | Өөрчлөлт % |
|---|---|---|---|---|
| Дуудлагын тоо | Тоо | 193 | 131 | -32.1% |
| Гал түймэр | Тоо | 168 | 96 | -42.9% |
| Иргэд унтраасан гал түймэр | Тоо | 25 | 25 | - |
| Өөрөө унтраасан гал түймэр | Тоо | 2 | 5 | 2.5[1] |
| Худал дуудлага | Тоо | - | 5 | 100.0% |
| Ажилласан цаг | Цаг.мин | 560 | 5 083 | 9.0[1] |
| Ашиглагдсан ус | Тонн | 108 | 471.3 | 4.4[1] |
| Ашиглагдсан шатхуун /дизель/ | Литр | 1 210 | 3 215.9 | 2.7[1] |
| Ашиглагдсан хөөс | Литр | - | - | - |
| Зарцуулсан мөнгө | Сая.төг | 7.5 | 41.4 | 5.5[1] |
| Аварсан хүний тоо | Тоо | 121 | 236 | 95.0% |
| Унтраасан барилга байшингийн тоо | Тоо | 115 | 67 | -41.7% |
| Нийт өмч хөрөнгө | Сая.төг | 920 | 15 478 | 16.8[1] |
| Амьсгалын бие даасан төхөөрөмж | Тоо | 98 | 445 | 4.5[1] |

[1]-Дахин их
* Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс

# ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, 2024 оны эхний 04 сарын байдлаар



| | Эд хөрөнгийн бүртгэл | Газар | Газраас бусад |
|---|---|---|---|
| Үйлчилгээний тоо | 1 333 | 2 517 | 4 025 |
| Үйлчилгээний хөлс (мян.төг) | 16 252.0 | 21 910 | 146 481 |

ҮҮНЭЭС:

Үйлчилгээний тоо

Үйлчилгээний хөлс (мян.төг)



**Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ:** 2024 оны 04 сард Улсын бүртгэлийн хэлтэс нь 7 төрлийн үйлчилгээг нийт 7875 иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 184.6 сая төгрөгийн хураамж авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс үйлчилгээ авсан хүн 337 (4.3%), үйлчилгээний хөлс 61.7 (33.4%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 10.3 ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, төрлөөр

| Үйлчилгээний төрөл | 2024 IV | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Эд хөрөнгийн бүртгэл | | Газар | | Газраас бусад | |
| | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (мян.төг) | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (мян.төг) | Үйлчилгээ-ний тоо | Үйлчилгээ-ний хөлс (мян.төг) |
| **Нийт** | **1 333** | **16 252** | **2 517** | **21 910** | **4 025** | **146 481** |
| Анхны бүртгэл | 80 | 16 | 144 | - | 447 | 1 709 |
| Өмчлөх эрх шилжих гэрээ | 272 | 5 440 | 511 | 10 208 | 776 | 15 484 |
| Барьцааны гэрээ | 855 | 10 283 | 1 450 | 9 919 | 2 427 | 127 476 |
| Бусад гэрээ | 2 | 20 | - | - | 12 | 90 |
| Бүртгэлд өөрчлөлт оруулах | 86 | 460 | 343 | 1 782 | 249 | 1 652 |
| Урьдчилсан тэмдэглэл | 2 | 10 | - | 1 | 6 | 10 |
| Лавлагаа хуулбар | 36 | 23 | 69 | - | 108 | 60 |

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

**Улаан загалмай:** Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2024 оны 04 сард 9789 хүнд 9230 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3468 хүнээр өссөн бол, зарцуулсан зардал 1865.0 мянган төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 10.4 ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, төрлөөр, эхний 4 сард

| Үзүүлэлт | 2023 IV | | | 2024 IV | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хэдэн удаа | Хамрагдсан хүний тоо | Зардал /мян.төг/ | Хэдэн удаа | Хамрагдсан хүний тоо | Зардал /мян.төг/ |
| **Дүн** | **101** | **6321** | **7365** | **177** | **9789** | **9230** |
| Халамж үйлчилгээ | 6 | 384 | 2060.0 | 16 | 682 | 7000.0 |
| Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа | 36 | 1234 | 3288.0 | 34 | 443 | 1300.0 |
| Анхны тусламжийн сургалт | 14 | 784 | 25 | 44 | 1097 | 300.0 |
| Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа | 6 | 526 | 40.0 | 21 | 691 | 300.0 |
| Гамшгийн тусламж | 1 | 20 | 1915.0 | 2 | 10 | 350.0 |
| Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа | 8 | 1933 | 10.0 | 8 | 3100 | 600.0 |
| Донорын өдөрлөг, сурталчилгаа | - | - | - | 6 | 2900 | 60.0 |
| Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа | 9 | 468 | - | 5 | 56 | 20.0 |
| Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа | 21 | 972 | 27.0 | 41 | 810 | 600.0 |

*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо

Халамжийн чиглэлээр сургалт, сурталчилгааг 16 удаа зохион байгуулж 682 иргэн, анхны тусламжийн сургалт 44 удаа зохион байгуулж 1097 иргэн, хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээр сургалтыг 5 удаа зохион байгуулж 56 иргэн, хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7-н зарчим, төр, улаан загалмайн хамтын ажиллагааны сурталчилгааг 41 удаа зохион байгуулж 810 иргэнийг тус тус хамруулсан байна.

Захиргааны мэдээлэл: Дүүргийн хэмжээнд 2024 оны эхний 4 сард 1192 иргэдээс өргөдөл, гомдол ирснээс 1011-г хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 164 нь шийдвэрлэх шатандаа хянагдаж, 17 нь хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байна. Нийт ирүүлсэн өргөдөл гомдлын 86.2 хувийг шийдвэрлэж хариу өгсөн байна.

ХҮСНЭГТ 10.5. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, 2024 оны эхний 4 сарын байдлаар

| Ангилал | 2024 он | Үүнээс: | |
|---|---|---|---|
| | | Шийдвэрлэх шатандаа байгаа | Шийдвэрлэж хариу өгсөн |
| Нийт | 1192 | 164 | 1028 |
| Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв | 7 | 2 | 5 |
| Нутгийн захиргааны байгууллагууд | 691 | 112 | 579 |
| 1800-1200 дугаарын оператор | 84 | 13 | 71 |
| 11-11 төвөөс ирсэн | 388 | 36 | 352 |
| Гар утасны аппликэйшнээр ирсэн | - | - | - |
| Мессеж | - | - | - |
| E-Service | 6 | 1 | 5 |
| Facebook | - | - | - |
| Дижитал сити | 8 | - | 8 |
| Хороо бүртгэсэн | 8 | - | 8 |
| НМХГ тусгай дугаар | - | - | - |

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

Танилцуулга хянасан хэлтсийн дарга: ................................ /Д.МӨНХЗУЛ/

Танилцуулгыг нэгтгэсэн мэргэжилтэн: .............................. /Г.ПҮРЭВСҮРЭН/